



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

30 **ХИЦУУЛАЛТ** 2023

NOVOTEL 2023.12.01

ИНТЕРНЭТИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГА

Х.НИНЖБОЛОР ЗБХГ-ЫН ХХСДБХ

www.crc.gov.mn

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА (ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД)

30 **ХИЦУУЛАЛТ** 2023

NOVOTEL 2023.12.01

Тусгай зөвшөөрөл

Энгийн зөвшөөрөл

Бүртгэл

Радио давтамжийн
зурвас

ХХ-ны сүлжээ
байгуулах

Сансрын холбооны
сүлжээ

Сүлжээ суурилүүлалт

Харилцаа
холбооны
үйлчилгээ
(ИНТЕРНЭТ)


Мэдээллийн сүлжээ
ашиглах

Шуудан

Өргөн нэвтрүүлэг

Нийтийн бус үйлчилгээ

Барилгын дотор
холбоо



| Түвшин | Зөвшөөрлийн тухай хууль | Зохицуулалт |
|----------------------------|--|--------------|
| Апп | Зөвшөөрөл олгохгүй | Үгүй |
| Түвшин | Зөвшөөрлийн тухай хууль | Зохицуулалт |
| Мэдээллийн сүлжээ ашиглагч | Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх | Тийм (Төсөл) |
| Түвшин | Зөвшөөрлийн тухай хууль | Зохицуулалт |
| Мэдээллийн сүлжээ | ИБҮЭ-Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх | Тийм |
| | МИХХ-Зөвшөөрөл олгохгүй | Журам |
| Түвшин | Зөвшөөрлийн тухай хууль | Зохицуулалт |
| Үйлчилгээ | Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх | Тийм |
| Түвшин | Зөвшөөрлийн тухай хууль | Зохицуулалт |
| Сүлжээ | Харилцаа/Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх | Тийм |
| Түвшин | Зөвшөөрлийн тухай хууль | Зохицуулалт |
| Үйлчилгээ | Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх | Тийм |

Харилцаа холбооны тухай хуулийн 16.1.

“Харилцаа холбооны сүлжээ нь цахилгаан холбоо, шуудан, радио, телевизийн болон мэдээллийн /интернет, компьютер зэрэг бусад/ сүлжээнээс бүрдэнэ” гэж заасан.

ITU-гаас 2021 онд баталсан ITU-T Y.2623 баримт бичигт интернетийг сүлжээ тодорхойлсон. Уг баримт бичигт тодорхойлсоноор “интернет гэж IP ашиглан өөр хоорондоо харилцан холбогдож, нэгдсэн нэг бүхэл, том виртуаль сүлжээг бий болгож буй олон төрлийн сүлжээний цогц” гэсэн.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА (ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД)

ЗОХИЦУУЛАЛТ 2023

NOVOTEL 2023.12.01

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
(ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД)
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН
ТӨСӨЛД

САНАЛ АВЧ БАЙНА

ЖУРАМ НЬ 8 БҮЛГЭЭС БҮРДЭНЭ:

I. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

II. ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЗОХИЦУУЛАЛТЫН ҮНДСЭН
ЗАРЧИМ

III. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ

IV. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

V. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ

VI. ХЭРЭГЛЭГЧИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШААРДЛАГА

VII. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР

VIII. БУСАД ЗҮЙЛ

төсөл

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл,
шаардлага
(Интернэтийн үйлчилгээнд)

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү баримт бичгээр харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн интернэтийн үйлчилгээ (цаашид "интернэтийн үйлчилгээ" гэх) эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтооно.

1.2. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд хэрэглэгчид интернэтийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргагч болон эзэмшигч нь (цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх) Монгол Улсын хууль тогтоомж, бодлого, шийдвэр, Монгол Улсын үндэсний стандарт, норматив баримт бичиг болон Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид "Зохицуулах хороо" гэх)-ноос баталсан журам, энэхүү нөхцөл, шаардлага болон энэхүү баримт бичгийн хүрээнд гаргасан Зохицуулах хорооны холбогдох шийдвэрийг дагаж мөрдөнө.

1.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос Харилцаа холбооны

1. БУСАД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙГ ДАГАЖ МӨРДӨХ

1.1. Энэхүү баримт бичгээр харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн интернэтийн үйлчилгээ (цаашид “интернэтийн үйлчилгээ” гэх) эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтооно.

2. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТЗ-ИЙГ ХУУЛИЙН ЭТГЭЭД АВАХ

1.2. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд хэрэглэгчид интернэтийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргагч болон эзэмшигч нь (цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх) Монгол Улсын хууль тогтоомж, бодлого, шийдвэр, Монгол Улсын үндэсний стандарт, норматив баримт бичиг болон Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ноос баталсан журам, энэхүү нөхцөл, шаардлага болон энэхүү баримт бичгийн хүрээнд гаргасан Зохицуулах хорооны холбогдох шийдвэрийг дагаж мөрдөнө.

3. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТЗ-ИЙН ХҮРЭЭНД ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ

1.3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасны дагуу хуулийн этгээдэд олгоно.

1.4. Интернэтийн үйлчилгээг Зохицуулах хорооноос олгосон Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлнэ.

4. ИНТЕРНЭТИЙН БӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДЭЭС ИНТЕРНЭТИЙН УРСГАЛ ТҮРЭЭСЛЭХ

1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг улс хоорондын сүлжээ байгуулах буюу интернэтийн бөөний урсгал түрээслэх эрхтэй (цаашид “интернэтийн бөөний үйлчлэгч” гэх) авсан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн сүлжээнд “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын дагуу холбогдоно.

5. ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

1.7. Интернэтийн үйлчилгээ гэж утастай, утасгүй (WiFi, mobile radio access гм) болон хиймэл дагуулын технологиор хэрэглэгчид гэрээний үндсэн дээр интернэт холболтын боломжийг бүрдүүлж, гэрээнд заасан хурдаар интернэтийн сүлжээнд холбох үйлчилгээг ойлгоно.

1.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэв харилцаа холбооны үйлчилгээнд хамаарах яриа, мессежийн үйлчилгээг хэрэглэгчид үзүүлэх тохиолдолд Зохицуулах хороонд хүсэлт гаргаж, шийдвэрлүүлнэ.

1. ИНТЕРНЭТИЙН ДУНДЫН ХОЛБОЛТЫН ТӨВД ХОЛБОГДОХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ
2. ИХТ-Д 2-Р ТҮВШИНД ХОЛБОЛТ ҮҮСГЭХ
3. ИХТ-Р ДАМЖИЖ БУЙ ХЭРЭГЛЭГЧИЙН УРСГАЛД ХЯЗГААРЛАЛТ ХИЙХГҮЙ
4. МУ-ЫН ХУУЛЬ ЗӨРЧСӨН ДОМЭЙН НЭР, КОНТЕНТ, МОБАЙЛ АППЛИКЭЙШНИЙГ ИНТЕРНЭТЭД ХОЛБОХГҮЙ
5. ЗӨРЧИЛТЭЙ КОНТЕНТИЙН МОНГОЛ УЛСААС ХАНДАХ ХАНДАЛТЫГ ХЯЗГААРЛАНА.

2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь интернэтийн бөөний үйлчлэгчийн сүлжээ болон Монгол Улсын интернэтийн дундын холболтын төвд холбогдохдоо Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэхь заалт, 22 дугаар зүйл болон Зохицуулах хорооноос баталсан холбогдох журмыг баримталж, гэрээ байгуулан ажиллана.

2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээний чанарыг сайжруулах, сүлжээ болон үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор интернэтийн дундын холболтын төвтэй 2-р түвшинд (layer 2) холболт үүсгэнэ.

2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төрөөс зохион байгуулсан интернэтийн дундын холболтын төвөөр дамжиж буй хэрэглэгчийн урсгалд ямар нэгэн хязгаарлалт хийхгүй.

2.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрх бүхий холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн дагуу Зохицуулах хорооноос зарласан Монгол Улсын хууль зөрчсөн домэйн нэр, контент, мобайл аппликэйшнийг өөрийн сүлжээгээр дамжуулан интернэтэд холбохгүй.

2.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн агуулга бүхий контентийг эрх бүхий холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэн Зохицуулах хорооноос шаардсаны дагуу тухайн контентийн Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлана.

1. ТЗ ХҮССЭН ӨРГӨДӨЛ, ТҮҮНД ХОЛБОГДОХ МАТЕРИАЛЫГ ХАВСАРГАЖ ИРҮҮЛЭХ

2. САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭРТЭЙ БАЙХ

3. МЭДЛЭГ ТУРШЛАГА БҮХИЙ МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ НӨӨЦТЭЙ БАЙХ

3.1. Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн талаарх танилцуулга, төлөвлөлт, үйлчилгээ хүргэх төлөвлөгөө, санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалт, үр ашгийн тооцоо зэргийг багтаасан бизнес төлөвлөгөөг тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд хавсаргаж ирүүлнэ.

3.2. Интернэтийн үйлчилгээ эрхлэх өргөдөл гаргагч нь харилцаа холбооны үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байна.

3.3. Өргөдөл гаргагч нь интернэтийн үйлчилгээ эрхлэхтэй холбоотой техник, тоног төхөөрөмжийн суурилуулалт, ашиглалт үйлчилгээ, тухайн чиглэлийн үйлчилгээний талаар мэдлэг туршлага бүхий мэргэжлийн хүний нөөцтэй байна. Үүнд:

3.2.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ерөнхий инженертэй байх бөгөөд мэдээлэл, холбооны зөвлөх инженер (Мэдээллийн сүлжээ, Мэдээллийн системийн аюулгүй байдал, Программ хангамж, мэдээллийн систем, Дамжуулах байгууламж, нягтруулгын систем)-ийн зэрэг буюу түүнтэй дүйцэхүйц олон улсын зэрэгтэй байна.

3.2.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн чиглэлийн ажлыг гардан гүйцэтгэж байсан туршлагатай 3 ба түүнээс дээш инженертэй байх ба аль нэг инженер нь мэдээлэл, холбооны мэргэшсэн (Мэдээллийн сүлжээ, Мэдээллийн системийн аюулгүй байдал, Программ хангамж, мэдээллийн систем, Дамжуулах байгууламж, нягтруулгын систем) зэрэгтэй буюу түүнтэй дүйцэхүйц олон улсын зэрэгтэй байна.

4.1-4.11

1. СҮЛЖЭЭГ УДИРДАХ, ХЯНАХ СИСТЕМ, ПХ-ТАЙ БАЙХ, ХЯНАЛТ ХЭМЖИЛТ ХИЙДЭГ БАЙХ

4.1.Интернэтийн үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор сүлжээний удирдлага, хяналтын нэгдсэн системтэй байна.

2. СТАНДАРТАД НИЙЦСЭН ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТЕХНИКИЙН ӨРӨӨТЭЙ БАЙХ

4.2.Интернэтийн үйлчилгээний чанар, стандарт болон норматив шаардлагыг ханган ажиллах зорилгын хүрээнд техник, тоног төхөөрөмжид байнгын хэмжилт, тогтмол хяналт хийх хэмжүүрийн багаж, хэрэгсэл эсхүл програм хангамжаар хангагдсан байна.

3. ГАДААД IP ХАЯГИЙГ IPv4 ≤ 20 ХЭРЭГЛЭГЧ, IPv6 ≤ 100 ХҮРТЭЛ ХЭРЭГЛЭГЧИЙН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ

4.3.Энэхүү нөхцөл шаардлагын 5.2-т заасан хяналтын програм хангамжид өөрийн үйлчилгээ хүргэж буй сүлжээний топологийг бүрэн хамруулсан байна.

4. IP ХАЯГИЙН ХУВИРГАЛТ АШИГЛАХ БОЛ ХЭРЭГЛЭГЧИЙН 1 УДААГИЙН ХОЛБОЛТ ДАХ БҮХ ХАНДАЛТ 1 ГАДААД IP – Р ДАМЖИХ, МЭДЭЭЛЛИЙГ 1 ЖИЛ ХАДГАЛАХ

4.4.Техникийн өрөө нь тухайн техник, тоног төхөөрөмжийн техникийн нөхцөлд заагдсан орчны шаардлага, MNS 6869:2020 Мэдээлэл, харилцаа холбооны техникийн өрөөнд тавих шаардлага (*температур, чийгшил, агааржуулалт г.м*) стандартыг хангасан байна.

5. BLACKLIST.MN ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ

4.5.Үндсэн техник, тоног төхөөрөмжийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор цахилгааны хоёроос доошгүй эх үүсвэрт холбогдсон байх бөгөөд нөөц зай тэжээлийн нөөц эх үүсвэр (*генератор, салхи болон нарны зай тэжээл гэх мэт*)-ийг зохион байгуулсан байна.

4.6.Интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгчтэй холбогдож байгаа үндсэн замчлагч төхөөрөмж (router) нь хэрэглэгчийн интернэтийн үйлчилгээний чанарын шаардлагыг хангахуйц холболттой байна.

4.7.Интернэтийн үйлчилгээнд гадаад АйПи (IPv4) хаягийг хамгийн ихдээ 20 хэрэглэгчийн дунд нэг байхаар зохион байгуулна.

4.8.Интернэтийн үйлчилгээнд гадаад АйПи хаягийн 4 болон 6-р хувилбарыг хослуулан ашиглах Дуал Стак технологийг нэвтрүүлсэн үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд" нэг гадаад АйПи хаягийг хамгийн ихдээ 100 хэрэглэгчийн дунд нэг байхаар зохион байгуулж болно.

4.9.Хэрэглэгчийн интернэт үйлчилгээнд АйПи (IP) хаягийн хувиргалт (NAT) ашиглах тохиолдолд хэрэглэгчийн нэг удаагийн холболт дах бүх хандалт нэг гадаад АйПи (IP) хаягаар дамжсан байх боломжийг бүрдүүлэх бөгөөд харгалзах /гадаад, дотоод/ хаягуудын мэдээллийг нэг жилийн хугацаанд хадгална.

4.10.Хөдөлгөөнт интернэтийн үйлчилгээ (Үүрэн холбооны үйлчилгээ 3G, 4G-LTE, утасгүй интернэтийн үйлчилгээ WiFi гэх мэт)-нд энэхүү нөхцөл шаардлагын 4.7, 4.8, 4.9, 7.2 дах заалт хамаарахгүй.

4.11.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь домэйн нэрийн системүүд (Domain Name System) болон сүлжээний хамгаалалтын төхөөрөмжүүд (Firewall) дээрээ www.black-list.mn домэйн нэрд харгалзах IP хаягаас ирэх домэйн нэрийн асуулга хүсэлтийг зөвшөөрөх, хариулах боломжийг бүрдүүлсэн байна.

4.12-4.19

6. IPv4, IPv6 НЭВТРҮҮЛЭХ

7. КИБЕР ХАЛДЛАГААС ХАМГААЛЖ АЖИЛЛАХ, ХАЛДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ХОРООНД ИРҮҮЛЭХ

8. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

9. ЗОХИЦУУЛАХ ХОРООГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХЯНАЛТ ХИЙХ ЗОРИЛГООР ТӨХӨӨРӨМЖ ХОЛБОХ БОЛОМЖООР ХАНГАХ

4.12. Зохицуулах хорооноос зохион байгуулсан сүлжээний цагийн нэгдсэн серверээр дамжуулан Монгол Улсын эталон цагтай холбогдож, эталон цагийг ашиглана.

4.13. АйПи хаягийн 4 болон 6-р хувилбарыг (IPv4, IPv6) хослуулан ашиглах (Dual-stack) техникийн боломжийг бүрдүүлсэн байна. Хэрэглэгчийн төхөөрөмжийг АйПи хаягийн 6 дугаар хувилбарыг (IPv6) дэмжин ажилладаг төхөөрөмжөөр шинэчлэх ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

4.14. Техник, тоног төхөөрөмж шинээр суурилуулах, өргөтгөх, шилжүүлэх, технологийн шинэчлэл нь хэрэглэгчийн үйлчилгээнд сөргөөр нөлөөлөхөөр бол авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Зохицуулах хороо болон хэрэглэгчдэд урьдчилан мэдээлнэ.

4.15. Үндсэн серверүүд (DNS, RRPoE биллинг)-ийг кибер халдлагаас хамгаалах, хэрхэн хамгаалж байгаа талаар үзлэг шалгалтыг батлагдсан хуваарийн дагуу тогтмол хийж, протокол тэмдэглэл хөтөлдөг байна.

4.16. Кибер халдлагын талаарх мэдээллүүдийг ангилж хагас жил тутам Зохицуулах хороонд хүргүүлнэ.

4.17. Интернэтийн порт (TCP, UDP)-ыг интернэтийн дугаар олгох байгууллага (IANA)-аас албан ёсоор тогтоон хуваарилсан жагсаалтыг баримтлан нээлттэй байлгана. Харин бусад албан бус портын дугаарыг нээлттэй байлгах тохиолдолд үйлчилгээгээр тусад нь ангилан хэрэглэгчдэд санал болгоно.

4.18. Үйлчилгээний чанарт хяналт тавих, бусад холбогдох хууль тогтоомжийг (Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын хууль гм) хэрэгжүүлэх ажлын хүрээнд Зохицуулах хорооноос баталгаажуулсан төхөөрөмжийг үйлчилгээ эрхлэгч өөрийн сүлжээнд холбох, шаардлагатай мэдээллүүдийг авах боломжоор Зохицуулах хороог хангана.

4.19. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос шаардсаны дагуу өөрийн үйлчилгээг хэрэглэгчид хүргэх сүлжээний төлөвлөлт, бүтэц, архитектур, бусад үйлчилгээний сүлжээ, системтэй холбогдсон байдал, техникийн үзүүлэлт, үйл ажиллагааны зарчмын талаарх тайлан мэдээллийг ирүүлнэ.

11. ЗОХИЦУУЛАХ ХОРООНД СҮЛЖЭЭ, СИСТЕМ, БУСАД СҮЛЖЭЭТЭЙ ХИЙСЭН ХОЛБОЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ИРҮҮЛЭХ

12. НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛСАН КОНТЕНТ (+18)-Д ХАНДАХ ХАНДАЛТЫГ ХЯЗГААРЛАХ ҮНДСЭН ТОХИРГООТОЙ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ БАЙХ

13. СҮЛЖЭЭ, СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ, ХЭМЖИЛТ ТОГТМОЛ ХИЙХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НАЙДВАРТАЙ, ТАСРАЛТГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

14. КОЛЛЕКТОР СЕРВЕРТЭЙ БАЙХ

4.20. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос шаардсаны дагуу дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

4.20.1. АПНИК (APNIC)-ээс авсан АйПи (IP) хаягийн блок болон ЭЙЭс (AS) дугаар;

4.20.2. Үндсэн (DNS) домэйн нэрийн серверийн IP хаяг;

4.20.3. Бүсчлэн хуваасан АйПи (IP) хаягууд, тэдгээрт харгалзах хурд болон төхөөрөмжүүдийн мэдээлэл;

4.20.4. Эталон цагт холбогдсон байдал;

4.20.5. Кэйш (cache) серверүүдийн ашиглалтын мэдээлэл;

4.20.6. Бусад үйлчилгээ эрхлэгчидтэй хийсэн шууд холболтын (Peer-to-peer) мэдээлэл.

4.21. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д заасны дагуу насанд хүрэгчдэд зориулсан контент (+18)-д хандах хандалтыг хязгаарлах (*системийн эсвэл програм хангамжийн*) үндсэн *тохиргоотой* үйлчилгээтэй байна. Энэхүү үйлчилгээг хэрэглэгчийн гэрээ болон өөрийн веб сайтаар дамжуулан иргэдэд санал болгож мэдээлнэ.

4.22. Төрийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудад интернэтийн үйлчилгээг хүргэхдээ насанд хүрэгчдэд зориулсан веб сайтыг хаадаг байна.

4.23. Хяналтын нэгдсэн системийн мэдээллийг 6 сараас доошгүй хугацаагаар архивлан хадгална.

4.24. Техникийн үзлэг, хэмжилтийг тогтсон хуваарийн дагуу тогтмол хийх, хэмжилтийн үр дүнг бүртгэлжүүлнэ. Үзлэг, хэмжилтийг хийх журам, заавар, техник, тоног төхөөрөмжийн ажиллагааг шалгах, хэмжих эсхүл гэмтэл саатлыг хянах, арга хэмжээ авах, хэрэглэгчийн гомдол, саналыг шийдвэрлэх зэрэг үйл ажиллагааг инженер техникийн ажилтан хэрхэн гүйцэтгэх заавар, дарааллыг тогтоосон технологийн картыг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөнө.

4.25. Үндсэн болон нөөц техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг тогтмол хугацаанд хэмжих, шалгах, тухайн техник, тоног төхөөрөмжийн гадна талд тэмдэглэгээ хийх, бүртгэл хөтөлнө.

4.26. Гадаад гарцын сүлжээнд гэмтэл саатал гарах үед авах арга хэмжээг тодорхойлсон, тэдгээрийг хэрэгжүүлэх, шийдвэрлэх техникийн боломжийг бүрдүүлсэн байна.

4.27. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь коллектор сервертэй байх ба уг серверээс шаардлагатай мэдээллүүдийг авах боломжоор Зохицуулах хороог хангана.

1. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФЫГ ТОГТООСОН АРГАЧЛАЛЫН ДАГУУ ТОГТООХ
2. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНД ИРҮҮЛЭХ
3. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ НЬ ИЛ ТОД, ҮЛ ЯЛГАВАРЛАСАН, ӨРТӨГТ БАРИМЖААЛСАН БАЙХ

5.1.Интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь тухайн үйлчилгээний зах зээлд шинээр үйл ажиллагаа эхлүүлэх, үндсэн үйлчилгээний үнэ тарифд өөрчлөлт оруулах тохиолдолд үйлчилгээний үнэ тарифын мэдээллийг холбогдох үндэслэл, тайлбарын хамт Зохицуулах хороонд ирүүлж, бүртгүүлнэ.

5.2.Интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь үйлчилгээний үнэ тарифаа Зохицуулах хорооноос баталсан аргачлалын дагуу тогтоож, олон нийтэд ил тод мэдээлнэ.

5.3.Үйлчилгээний үнэ тариф нь ил тод, үл ялгаварласан, эдийн засгийн бололцоог тооцсон өртөгт баримжаалсан байна.

ЗУРГАА.ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШААРДЛАГА

30 **ХИЦУУЛАЛТ** 2023

NOVOTEL 2023.12.01

1. ВЕБ ХУУДАСТАЙ БАЙХ

2. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА, ГЭРЭЭ, ҮНЭ ТАРИФЫН МЭДЭЭЛЛИЙГ МЭДЭЭЛДЭГ БАЙХ

3. ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨХӨӨРӨМЖ НЬ БАТАЛГААЖСАН БАЙХ, ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨХӨӨРӨМЖИЙГ СҮЛЖЭЭНД ХОЛБОХООС ТАТГАЛЗАХ

4. ХЭРЭГЛЭГЧИЙГ ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭЛЭЛ, ЗӨВЛӨМЖӨӨР ХАНГАЖ АЖИЛЛАХ

5. ХЭРЭГЛЭГЧИЙН САНАЛ, ГОМДЛЫГ ХҮЛЭЭН АВЧ, ШУУРХАЙ ШИЙДВЭРЛЭДЭГ БАЙХ

6.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн интернэтийн үйлчилгээнд зориулсан вэб хуудастай байна.

6.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээний нөхцөл, шаардлага, гэрээ, үнэ тарифын талаарх мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр боловсруулж, өөрийн веб сайт болон боломжит бусад сувгуудаар мэдээлнэ.

6.3.Хэрэглэгчийн төхөөрөмж нь Монгол Улсаас олон улс, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ хэлэлцээрээр хүлээн зөвшөөрөгдсөн баталгаажуулалтын гэрчилгээ, тохирлын гэрчилгээ, аюулгүйн тэмдэгтэй байна.

6.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь стандартын шаардлага хангахгүй төгсгөлийн төхөөрөмжийг холбох, түүнийг ашиглан үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.

6.5.Хэрэглэгчийн төхөөрөмж болон бусад дагалдах хэрэгслийг борлуулах, засвар үйлчилгээ үзүүлэх цэг ажиллуулах ба ашиглалтын заавар зөвлөмж, мэдээллээр хэрэглэгчийг тогтмол хангаж ажиллана.

6.6.Хэрэглэгчээс интернэтийн үйлчилгээтэй холбоотой гомдол, санал (веб сайтаар дамжуулан) хүлээж авах, шийдвэрлэх журамтай байх ба гомдол маргааныг үл ялгаварлах, шуурхай байдлаар шийдвэрлэнэ.

6.7.Хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа хэрэглэгчийн эрх ашгийг зөрчихгүй, хэт нэг талыг барихгүй, эрх тэгш, шударга байх зарчмыг баримтална.

6.8.Давагдашгүй хүчин зүйлийн улмаас үйлчилгээ үзүүлэх боломжгүй болох, тусгай зөвшөөрөл нь дуусгавар болох, хүчингүй болох эсвэл дампуурах тохиолдолд хэрэглэгчийг хохироохгүй байх арга хэмжээг авах, энэ талаар үйлчилгээний журам, нөхцөл шаардлагадаа заавал тусгасан байна.

ДОЛОО.ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР

30 **ХИЦУУЛАЛТ** 2023

NOVOTEL 2023.12.01

1. ХЭРЭГЛЭГЧИЙГ ИНТЕРНЭТИЙН ЧАНАРЫГ ХЯНАХ АРГА, ЗӨВЛӨМЖӨӨР ХАНГАХ

7.1.Интернэтийн чанар, урсгалын хурдыг хянахад зориулж интернэтийн чанарыг шалгах арга зам, зөвлөмжийг өөрийн үйлчилгээний веб сайтад байршуулна.

2. ДОТООД КОНТЕНТИЙН УРСГАЛД ХУРДНЫ ХЯЗГААРЛАЛТ ТАВИХГҮЙ, ГАДААД УРСГАЛД ХЭРЭГЛЭГЧИЙН ГЭРЭЭНД ЗААСАН ХУРДААР ХОЛБОХ

7.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт байршиж байгаа контентийн урсгал (веб, имэйл, файл хостинг, клоуд, видео стриминг, төрийн үйлчилгээ гэх мэт хэрэглээ)-д хурдны хязгаарлалтгүй холбох бөгөөд гадаад урсгалд хэрэглэгчтэй байгуулсан гэрээнд заасан хурдаар холбоно.

3. ЗОХИЦУУЛАХ ХОРООНД КЭЙШ СЕРВЕРИЙН МЭДЭЭЛЛИЙГ ИРҮҮЛЭХ

7.3.Үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор кэйш (cache) серверүүд байршуулсан тухай бүрд Зохицуулах хороонд мэдэгдэх, тэдгээрийн ашиглалтын мэдээллийг Зохицуулах хорооноос шаардсаны дагуу ирүүлнэ.

4. ИНТЕРНЭТИЙН ЧАНАР ХЯНАХТАЙ ХОЛБООТОЙ СТАНДАРТ, БАРИМТ БИЧИГ, ХОЛБОГДОХ ҮЗҮҮЛЭЛТИЙГ МӨРДӨХ

7.4.Олон улсын стандарт, Монгол Улсын MNS 6966:2022 Интернэтийн чанарт тавих шаардлага стандарт болон Зохицуулах хорооноос интернэтийн үйлчилгээний чанарыг хянахтай холбоотой зохицуулалтыг мөрдөнө.

7.5.Хэрэглэгчийн гэрээлсэн хурдны хэмжээ оргил ачааллын цагаар хамгийн багадаа **75 хувиас багагүй** байхаар ачааллын хэмжээг тооцоолж, зохион байгуулна. Үйлчилгээний чанарт байнгын хяналт тавих боломжоор Зохицуулах хороог хангана.

5. ЗОХИЦУУЛАХ ХОРООНД КЭЙШ СЕРВЕРИЙН МЭДЭЭЛЛИЙГ ИРҮҮЛЭХ

7.6.Нийт хэрэглэгчийн гадаад интернэт урсгалын хэрэглээний хэмжээг **10-аас доошгүй хувийн нөөцтэй** байхаар тооцож сүлжээний тусгай зөвшөөрөл эзэмшигчээс түрээсэлнэ. Интернэтийн урсгалын хэрэглээний хэмжээ нөөцөөс хэтэрсэн тохиолдолд урсгалын хэмжээг хангалттай хэмжээнд хүртэл нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллана.

7.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь **Улаанбаатар хотод 50 Мбит/сек, аймгийн төвд 10 Мбит/сек ба түүнээс дээш** гадаад интернэтийн урсгалыг түрээсэлнэ. (Сум суурин газарт дээрх нөхцөл хамаарахгүй)

30 **ХИЦУУЛАЛТ** 2023

NOVOTEL 2023.12.01



АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА

Харилцаа Холбооны Зохицуулах Хороо
Метро бизнес төв А-блок 5 давхар
Д.Сүхбаатарын гудамж-13 Сүхбаатар
дүүрэг, УБ 14201-0033

Утас: +976-11-304258
Факс: +976-11-327720
Цахим хуудас: www.crc.gov.mn
Цахим хаяг: info@crc.gov.mn